

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын ГЭРЧИЛГЭЭ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Бизнес төлөвлөгөө, зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Д.МАНДАХ ТАНАА

2020. 03.13 № 06/813
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу, үнэн бодит, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус төсөлд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


Үүрэг, хариуцлага

Монгол улсын боловсролын их сургууль нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Мандах Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн программын шинэчлэл хийх, бараа, ажил үйлчилгээний худалдан авалтын анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангах, Шилэн дансны тухай хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 01-ээс 2020 оны 03 дугаар сарын 09-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Нийслэл аудит” ХХК-ийн Захирал С.Сугарсүрэн, чанарын хяналтын менежер С.Сэрчхорол, ахлах аудитор Д.Ганзориг, аудитор Б.Өлзийзаяа, Д.Ариунбулган ахлах шинжээч Д.Чулуунбаатар, Д.Доржпүрэв, туслах аудитор Д.Энхтуяа, Д.Ариунцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 1/313 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Боловсролын Их Сургууль нь "Хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай багш, боловсролын салбарын мэргэжилтэн бэлтгэн гаргах, эрдэм шинжилгээ, инноваци, сургалтын аргазүй, технологийг хөгжүүлэх, боловсролын үйлчилгээний чанарыг орчин үеийн их сургуулийн түвшинд хүргэх, багш боловсролын чанараар Ази тивд өрсөлдөхүйц их сургууль байх, сургалт, судалгаа хосолсон нээлттэй, орчин үеийн их сургууль байх" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллаж байна.

Монгол Улсын Боловсролын Их Сургууль нь Боловсрол Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын төсвийн багцад нэгтгэгддэг. "Хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай багш, боловсролын салбарын мэргэжилтэн бэлтгэн гаргах" гэсэн эрхэм зорилгын хүрээнд 9 салбар сургууль, 3 дотоод алба нэгж гэсэн бүтэц бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант хугацаанд сургуулийн бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт хийгдэж Сургалт үйлдвэрлэлийн төвийг Дүрслэх урлаг технологийн сургуульд, Хэвлэх цехийг Ерөнхий боловсролын сургуульд нэгтгэсэн байна. Мөн сургуулийн удирдах зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 04 тоот тогтоолоор окуутны сургалтын төлбөрийг шинэчлэн тогтоосон.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Монгол улсын Боловсролын Их Сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Acolous", "Plastic" программ хангамж ашигладаг байна.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 2 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 17,304.5 сая төгрөгөөс тооцон 346.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 660.6 сая төгрөгөөр тооцсон нь өссөн дүнгээр илэрхийлэгдсэн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцсонтой холбоотой болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,152.8 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	25,986.7	22,801.8	(3,184.8)
Авлага	9,422.7	9,268.3	(154.4)
Урьдчилгаа	1,512.1	413.3	(1,098.8)
Бараа материал	103.1	170.3	67.2
Үндсэн хөрөнгө	66,786.0	69,003.9	2,217.9
Нийт хөрөнгө	103,810.6	101,657.8	(2,152.8)
Өр төлбөр	8,800.1	8,197.0	(603.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	14,067.0	14,462.7	395.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	103,810.6	101,657.8	(2,152.8)

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, ба үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

МУБИС-ийн удирдлага Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны 2019 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 12/6337 тоот албан бичигт үндэслэн тайлант он болон өмнөх онуудад үүссэн 3,855.4 сая төгрөгийн тогтмол зардал, хөрөнгө оруулалтын авлагыг хааж бууруулах, Капитал банк татан буугдсан холбоотойгоор тус банкинд байршуулсан 2,000.0 сая төгрөгийн хадгаламжийн дүнгээр өсгөх бичилтийг авлага дансанд хийсэн байна. Мөн санхүүгийн тайланд 1,636.1 сая төгрөгийн он удаан жил болж байгаа оюутан суралцагсдаас авах авлага тусгагдсан бөгөөд сургуулийн удирдлага хууль хяналтын байгууллагад шийдвэрлүүлэхээр шилжүүлжээ. Аудитаар санхүүгийн тайланд тусгагдсан өндөр дүнтэй авлагуудад тулган баталгаажуулалтын горим гүйцэтгэхэд зөрүү гараагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 67.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд худалдан авсан бараа материал болон сургууль хооронд шилжүүлсэн хөрөнгөөс шалтгаалсан. Бараа материалын үлдэгдэлд 32.5 сая төгрөгийн 10000 ширхэг цахим картын нөөц үүссэн бөгөөд шалтгааныг тодруулахад ширхэгээр худалдан авахад үнэтэй байсан бөгөөд олон ширхэгээр авснаар 17.5 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Мөн 2019 онд хөрөнгө оруулалтаар 18.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэсэн байна. Санхүүжүүлэгч байгууллагууд нь БСШУСЯам болон харьяа байгууллагуудаас 10.3

сая төгрөгийн бараа материал, Моноцүкүри төвөөс 7.1 сая төгрөгийн үнэ бүхий бараа материалуудыг тус тус хандивласныг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 72 тоот тогтоолоор сургуулийн албан хэрэгцээнд зориулан нийт 7,049.1 сая төгрөгт багтаан өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр үндсэн хөрөнгө олж авах, 11 дүгээр сарын 19-ны өдрийн 486 тоот тогтоолоор 934.4 сая төгрөгийн элэгдлийн хугацаа дууссан ашиглагдах боломжгүй болсон хөрөнгийг актлах зөвшөөрөл олгогдсон байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь 6,906.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд худалдан авсан үндсэн хөрөнгө болон бусад эх үүсвэрээс бэлтгэгдсэн үндсэн хөрөнгөнөөс шалтгаалжээ.

Тайлант хугацаанд 4,897.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дотоод эх үүсвэрээр, 485.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хандиваар тус тус бэлтгэсэн байна. Дээд боловсролын шинэчлэлийн төслөөс 146.0 сая төгрөгийн, Боловсролын чанарын төслөөс 120.8 сая төгрөгийн, Спортыг дэмжих сангийн төслөөс 101.1 сая төгрөгийн, БСШУСЯ-аас 63.0 сая төгрөгийн, бусад эх үүсвэрээс 54.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хандивласан байна.

2018 онд баригдаж эхэлсэн 3,801.7 сая төгрөгийн барилга, 2019 онд эхэлсэн Ерөнхий боловсролын сургуулийн 844.4 сая төгрөгийн өргөтгөлийн давхрын барилгыг улсын комиссын актаар барилга байгууламж дансанд бүртгэж, 187.9 сая төгрөгийн их засварын зардлыг капиталжуулсан байна.

Аудитаар дээрх бараа ажил үйлчилгээний худалдан авалт холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэхийг нэг бүрчлэн шалгахад ямар нэгэн зөрчил илрээгүй байна. Мөн 2019 онд сургуулийн бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орж зарим салбар нэгжийг нэгтгэсэн бөгөөд аудитаар хөрөнгийг дотооддоо шилжүүлсэн бичилтийг давтан шалгалаа.

МУБИС нь 2019 онд 780.0 сая төгрөгийн сургалт удирдлага мэдээллийн нэгдсэн систем, 198.6 сая төгрөгийн хичээлийн хяналтын программ, 7.9 сая төгрөгийн дотоод сүлжээний программ, 0.3 сая төгрөгийн архив бичиг хэрэг хөтлөлтийн программ худалдан авч биет бус хөрөнгийн дансанд бүртгэсэн байна. Биет бус хөрөнгийн дансанд аудит хийх явцад зөрчил илрээгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл нь 603.1 сая төгрөгөөр буурсан нь 2018 онд төслийн урьдчилж орсон орлого буюу 50.1 сая төгрөг сургалтын төлбөрийг урьдчилж орсон 480.0 сая төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрсөн, 73.0 сая төгрөгийн өглөг барагдуулснаас шалтгаалжээ

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 14,462.7 сая төгрөг болж 395.7 сая төгрөгөөр өссөн нь Тэрэлж дэх сургалт үйлдвэрлэлийн баазын газрыг эзэмших эрхийг бүртгэснээс шалтгаалжээ. МУБИС-ийн удирдлага дээрх нэмэгдсэн дүнгээр улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулахаар холбогдох байгууллагад хандсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 3,854.9 сая төгрөгийн бичилт нь өмнөх онуудад үүссэн БСШУСЯ-аас авах тогтмол зардлын 3,045.4 сая төгрөг, хөрөнгө оруулалтын 810.0 сая төгрөгийн, түрээсийн 8.0 сая төгрөг авлагыг холбогдох байгууллагын шийдвэрээр хааж, акталсан хөрөнгийн дахин үнэлгээний хэрэгжсэн дүн 5.4 сая төгрөг, өмнөх оны өглөг болох 3.2 сая төгрөгийг өмнөх үеийн үр дүн рүү хааснаас шалтгаалжээ.

2.9. Бизнес төлөвлөгөө, зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

МУБИС нь тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас 34,924.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 33,146.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 95 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	28,231.0	28,218.8	12.2	100.0
Туслах үйл ажиллагааны орлого	4,076.0	4,784.2	708.2	117.0
Улсын төсвийн санхүүжилт	2,617.0	143,3	(2,473.7.)	5.0
Нийт дүн	34,924.1	33,146.4	(1,777.7)	95.0

Нийт орлого 1,777.7 сая төгрөгөөр тасарсан нь 2019 оны төсвийн тухай хуулиар төрийн өмчийн их дээд сургуулиудад тогтмол зардал олгохгүй болж улсын төсвийн санхүүжилт орж ирээгүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд сургуулийн үйл ажиллагааны зардалд зориулан 34,924.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 26,084.6 сая төгрөгийг урсгал зардалд, 8,545.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулж, 1,237.5 сая төгрөгийг хөгжлийн санд төвлөрүүлэхээр батлагджээ.

Нийт зардлын 32,307.1 сая төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлогоор, 2,617.0 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

МУБИС нь 2019 онд үйл ажиллагааны урсгал зардалд 36,678.2 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 31,421.4 сая төгрөг зарцуулсан байна. Тогтмол зардал, урсгал засварын зардал нь шинээр баригдаж буй хичээлийн байр тодорхой шалтгааны улмаас хугацаандаа ашиглалтад ороогүй, хичээл үйлдвэрлэл дадлагын зардал нь 2018 онд элсэгчдийн тоо буурсантай холбоотойгоор материаллаг дүнгээр хэмнэгдсэн нь байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Тайлант хугацаанд гадаад төсөл хөтөлбөрөөс нийт 714.5 сая төгрөгийн санхүүжилт орж ирсэн байна. Эдгээр төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэгчээр дэлгэрэнгүй харуулбал.

№	Төсөл хөтөлбөрийн санхүүжүүлэгч	Дүн
1	Күнзийн институтын төслийн санхүүжилтээр	214.6
2	Дээд боловсролын шинэчлэл төслийн санхүүжилтээр	115.9
3	Нэгдсэн үндэстэний байгууллагын төслийн санхүүжилтээр	163.5
4	Нээлттэй нийгэм форм төслийн санхүүжилтээр	88.3
5	Нидерланд улсын "Гронинген ИС" төслийн санхүүжилтээр	12.2
6	"ЕХ арроу" төслийн санхүүжилтээр	69.0
7	Япон улсын Нагоя их сургуулийн шугамаар хэрэгжиж байгаа төслийн санхүүжилтээр	26.6
8	ОУ-ын "Дэлхийн зөн" байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслийн санхүүжилтээр	4.1
9	One asia foundation төслийн санхүүжилтээр	20.3
	Нийт дүн	714.5

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 14 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн нийт 145.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Бараа материалын худалдан авалтын анхан шатны баримтын бүрдэл, өндөр дүнтэй бараа ажил үйлчилгээний худалдан авалтын тендер шалгаруулалт холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж байгаа эсэх, хандив тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 134 мэдээллийг хугацаанд нь, 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Бүрэлдэхүүн сургууль, салбар нэгжүүд нь үйл ажиллагаандаа зориулан нийт 23,305.7 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа 2.2 сая төгрөгийн ажил гүйлгээний Е баримтыг сугалааны дугаар бүхий хувь хүнээр бүртгүүлсэн, 121.5 сая төгрөгийн ажил гүйлгээ Е баримтгүй, 1.5 сая төгрөгийн хуулийн хүчин төгөлдөр бус баримттай, 20.5 сая төгрөгийн ажил гүйлгээ анхан шатны баримтгүй зөрчил тус тус илэрсэн.

Эдгээр зөрчлүүд нь аудитын нийт олонлогийн 0.6 хувь буюу материаллаг бус дүнтэй байгаа боловч Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т Үнэн зөв байх; 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

3.1.2. Эрсдэл:

- Байгууллагын мөнгөн хөрөнгө хяналтгүй зарцуулагдаж залилан шамшигдал гарах;
- Бараа, ажил гүйлгээний худалдан авалт анхан шатны баримтаар нотлогдохгүй байх;
- Холбогдох хууль тогтоомж үйл ажиллагаанд хэрэгжихгүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6 заалтад нийцүүлэн, Сангийн сайдын 2018 оны 347 дугаар тушаалын хавсралтад заасны дагуу цахим гарын үсэг, тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны баримтаар бараа ажил үйлчилгээний худалдан авалтыг хийж бүртгэлд тусгах;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

3.2 Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

МУБИС-ийн нягтлан бодох бүртгэлийн программаас гарч байгаа ерөнхий журнал бүртгэлийн системийн маягт нь Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалаар батлагдсан аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягтыг хөтлөх аргачлалд нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн програмаас гарч байгаа ерөнхий журнал бүртгэлийн системийн маягт нь байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягтыг хөтлөх аргачлалд нийцэхгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн программд холбогдох хууль, заавар, журмын өөрчлөлтийг тусгаж шинэчлэл хийх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

3.3 Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн тухай

3.3.1 Илрүүлэлт

Монгол Улсын Боловсролын Их Сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын дагуу тогтмол хугацаанд нийт 149 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулахаас 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байгаа нь хуулийн 4.1.3-д “Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл

Шилэн дансанд мэдээллийг хоцроож байршуулж байгаагаас олон нийтэд мэдээлэл тогтмол хугацаанд шуурхай хүрэхгүй байх,

3.3.3 Өгсөн зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-д “Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлэх” гэж заасны дагуу мэдээллийг бүрэн оруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	37,024,604,511.34	32,653,859,699.29
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	25,986,666,644.63	22,801,844,949.20
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	14,405,168,755.44	16,774,244,296.64
31210	Төгрөг	14,405,168,755.44	16,774,244,296.64
31213	Арилжааны банк дахь харилцах	14,405,168,755.44	16,774,244,296.64
31500	Хадгаламж	11,581,497,889.19	6,027,600,652.56
33	АВЛАГА	9,422,720,541.37	9,268,351,411.24
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,868,539.00	1,112,500.24
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	6,263,630,623.86	7,168,817,684.10
33500	Бусад авлага	3,157,221,378.51	2,098,421,226.90
33510	Байгууллагаас авах авлага	3,139,201,502.51	2,084,232,361.90
33520	Хувь хүмүүсээс авах авлага	18,019,876.00	14,188,865.00
34	УРЬДЧИЛГАА	1,512,097,821.84	413,316,958.00
34600	Урьдчилж гарсан зардал	599,476,806.44	371,216,771.00
34710	Урьдчилгаа тооцоо	912,621,015.40	42,100,187.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	17,739,820.00	279,500.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	853,195,500.00	38,320,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	7,570,351.00	3,500,687.00
34714	Томилолтын урьдчилгаа	34,115,344.40	-
35	БАРАА МАТЕРИАЛ	103,119,503.50	170,346,380.85
35100	Түүхий эд материал	38,500.00	38,500.00
35130	Эм боох материал	38,500.00	38,500.00
35400	Хангамжийн материал	103,081,003.50	170,307,880.85
35410	Бичиг хэргийн материал	50,627,046.50	92,242,896.00
35420	Аж ахуйн материал	51,867,807.00	69,470,919.85
35430	Сэлбэг хэрэгсэл	243,800.00	156,400.00
35440	Түлш, шатах тослох материал	-	3,000,000.00
35450	Барилгын засварын материал	46,200.00	-
35460	Хүнсний материал	146,250.00	888,265.00
35470	Бусад хангамжийн материал	149,900.00	4,549,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	66,786,046,277.55	69,019,819,428.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	66,786,046,277.55	69,019,819,428.67
39200	Биет хөрөнгө	65,010,138,756.17	65,774,290,630.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	52,999,139,962.84	57,833,082,358.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	(236,525,124.90)	(1,916,543,296.95)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	398,304,898.00	455,304,898.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(261,129,898.42)	(291,279,898.32)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	7,564,475,028.71	8,470,627,165.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,409,023,263.09)	(4,856,755,225.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,470,709,102.79	6,561,090,877.61
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,589,244,193.72)	(3,854,968,207.16)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,175,127,233.07	1,196,717,133.07
39210	Хуримтлагдсан элэгдэл	(5,940,302.18)	(113,606,551.62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	113,917,834.00	147,177,834.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(27,890,877.65)	(37,302,545.75)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	3,801,655,597.00	1,049,978,438.00
39217	Ном	1,016,562,759.72	1,130,767,651.96
39300	Биет бус хөрөнгө	1,775,907,521.38	3,245,528,797.80
39301	Програм хангамж	753,460,949.90	1,901,174,426.40

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39302	Хуримтлагдсан элэгдэл	(610,355,788.52)	(684,129,514.06)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,632,802,360.00	2,028,483,885.46
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	103,810,650,788.89	101,673,679,127.96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,800,131,070.13	8,196,982,964.75
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,800,131,070.13	8,196,982,964.75
41300	Өглөг	546,148,441.26	472,831,681.28
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,087,724.00	2,860,518.90
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	77,650.88	-
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	57,487,400.00	43,218,200.00
41360	Бусад өглөг	484,495,666.38	426,752,962.38
41361	Байгууллагад төлөх өглөг	436,205,186.00	420,459,986.50
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,929,467.83	1,827,467.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	3,903,359.48	4,465,508.88
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	42,457,653.07	-
41400	Урьдчилж орсон орлого	8,253,982,628.87	7,724,151,283.47
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	427,536,817.21	377,742,781.26
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	7,826,445,811.66	7,346,408,502.21
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	95,010,519,718.76	93,476,696,163.21
51	Засгийн газрын хувь оролцоо	95,010,519,718.76	93,476,696,163.21
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,067,025,794.23	14,462,707,319.69
51200	Хуримтлагдсан үр дүн	48,356,705,984.44	46,432,570,747.72
51210	Өмнөх үеийн үр дүн	44,486,187,160.47	44,501,816,179.92
51220	Тайлант үеийн үр дүн	3,870,518,823.97	1,930,754,567.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	32,586,787,940.09	32,581,418,095.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	103,810,650,788.89	101,673,679,127.96

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	34,110,514,498.81	34,934,210,921.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,633,975,389.51	34,010,990,031.86
120	Нийтлэг татварын бус орлого	31,474,865,049.51	33,822,961,631.86
120002	Хүүгийн орлого	2,077,501,379.22	1,728,512,746.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,288,220,157.29	32,008,492,071.19
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,105,192,671.40	27,824,223,479.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,438,812,407.74	2,968,782,499.40
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	345,837,660.46	712,146,852.09
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	398,377,417.69	503,339,240.70
120005	Түрээсийн орлого	107,432,518.00	85,674,190.00
120009	Бусад орлого	1,710,995.00	282,624.50
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	159,110,340.00	188,028,400.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	159,110,340.00	188,028,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,476,539,109.30	923,220,890.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	305,291,100.00	758,760,200.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	305,291,100.00	758,760,200.00
1330	Төсвийн захирагчдаас	2,171,248,009.30	164,460,690.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	556,253,657.00	0
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	1,614,994,352.30	164,460,690.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	29,179,735,103.33	33,027,244,165.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,179,735,103.33	33,027,244,165.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,947,952,529.33	31,459,506,399.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,091,990,126.61	17,649,020,417.80
210101	Үндсэн цалин	16,091,990,126.61	17,649,020,417.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,926,021,609.10	2,207,059,456.84
210201	Тэтгэврийн даатгал	1,296,865,471.02	1,515,452,048.32
210202	Тэтгэмжийн даатгал	160,581,677.51	177,225,145.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	124,657,701.79	140,400,835.26
210204	Ажилгүйдлийн даатгал	30,568,834.48	33,244,377.95
210205	Эрүүл мэндийн даатгал	313,347,924.30	340,737,049.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,614,994,352.30	1,585,556,361.39
210301	Гэрэл, цахилгаан	472,071,457.00	527,035,331.55
210302	Түлш, халаалт	927,420,513.00	841,041,073.17
210303	Цэвэр, бохир ус	215,502,382.30	217,479,956.67
2104	Хангамж, бараа материалын зардал	1,460,359,704.73	1,310,600,226.33
210401	Бичиг хэрэг	242,647,838.50	247,813,887.50
210402	Тээвэр, шатахуун	46,633,348.00	39,541,634.18
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	309,727,372.03	273,509,421.25
210404	Ном, хэвлэл	59,236,556.78	63,133,809.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	37,858,000.00	45,183,147.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	341,953,114.96	369,890,932.40
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	234,328,088.81	271,527,395.00

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210408	Бараа материал акталсны зардал	187,975,385.65	0
2105	Нормативт зардал	92,483,037.50	92,983,202.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,221,475.50	2,990,460.00
210502	Хоол, хүнс	67,602,162.00	80,247,742.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,659,400.00	9,745,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,535,364,130.00	1,251,640,090.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	42,382,510.00	19,317,747.00
210602	Тавилга	30,183,800.00	1,265,500.00
210604	Урсгал засвар	1,462,797,820.00	1,231,056,843.00
2107	Томилолт, зочны зардал	404,913,674.02	539,464,648.62
210701	Гадаад албан томилолт	259,459,051.00	385,222,351.22
210702	Дотоод албан томилолт	53,489,720.00	73,093,100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	91,964,903.02	81,149,197.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	614,598,300.16	989,754,277.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	614,598,300.16	989,754,277.59
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,207,227,594.91	5,833,427,718.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,177,598,318.46	123,164,684.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	616,955,330.00	2,173,249,053.63
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,412,673,946.45	3,537,013,980.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	231,782,574.00	1,567,737,766.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	231,782,574.00	1,567,737,766.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,850,000.00	21,906,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	225,932,574.00	1,545,831,766.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,930,779,395.48	1,906,966,756.45
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	41,961,049.76	26,329,566.98
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	39,561,049.76	25,329,566.98
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	2,400,000.00	1,000,000.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,102,221,621.27	2,541,755.63
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	33,848,250.00	2,541,755.63
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	5,735,817.52	0
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	40,252,777.88	0
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	1,022,384,775.87	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,870,518,823.97	1,930,754,567.80

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	32,768,445,079.21	32,120,762,325.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,685,438,130.21	27,006,966,522.37
120	Нийтлэг татварын бус орлого	27,526,327,790.21	26,818,938,122.37
120002	Хүүгийн орлого	2,077,501,379.22	1,728,512,746.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,352,936,800.99	24,982,109,021.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,151,220,143.16	21,578,048,492.31
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,515,296,308.80	2,689,573,550.67
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	686,420,349.03	714,486,978.72
120005	Түрээсийн орлого	94,641,110.00	108,256,750.00
120009	Бусад орлого	1,248,500.00	59,604.50
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	159,110,340.00	188,028,400.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	159,110,340.00	188,028,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,083,006,949.00	5,113,795,803.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,438,028,650.00	4,814,762,800.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	4,438,028,650.00	4,814,762,800.00
1330	Төсвийн захирагчдаас	489,003,017.00	162,023,090.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	76,253,657.00	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	412,749,360.00	162,023,090.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	155,975,282.00	137,009,913.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	155,975,282.00	137,009,913.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,967,795,541.84	30,719,604,314.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	27,967,795,541.84	30,719,604,314.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,460,357,539.84	30,266,468,258.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,223,878,657.94	17,698,982,773.57
210101	Үндсэн цалин	16,223,878,657.94	17,698,982,773.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,765,606,898.63	2,206,524,682.84
210201	Тэтгэврийн даатгал	1,224,737,142.13	1,514,947,276.32
210202	Тэтгэмжийн даатгал	138,218,308.51	177,225,152.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	107,355,503.56	140,370,835.26
210204	Ажилгүйдлийн даатгал	26,354,827.13	33,244,373.95
210205	Эрүүл мэндийн даатгал	268,941,117.30	340,737,044.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,614,994,352.30	1,585,556,361.39
210301	Гэрэл, цахилгаан	472,071,457.00	527,035,331.55
210302	Түлш, халаалт	927,420,513.00	841,041,073.17
210303	Цэвэр, бохир ус	215,502,382.30	217,479,956.67
2104	Хангамж, бараа материалын зардал	1,091,699,662.17	1,057,342,394.49
210401	Бичиг хэрэг	125,990,955.00	139,971,023.00
210402	Тээвэр, шатахуун	46,264,601.00	42,200,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	309,981,072.03	273,904,921.25
210404	Ном, хэвлэл	109,732,199.78	71,062,009.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	37,858,000.00	44,383,147.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	461,872,834.36	485,820,644.24

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	107,819,207.00	115,380,574.26
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,155,000.00	5,280,460.00
210502	Хоол, хүнс	67,323,207.00	87,166,814.26
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	33,341,000.00	22,933,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,017,941,752.00	1,806,274,883.80
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,817,010.00	138,643,321.00
210602	Тавилга	184,442,900.00	27,217,450.00
210604	Урсгал засвар	2,787,681,842.00	1,640,414,112.80
2107	Томилолт, зочны зардал	426,189,324.02	507,855,586.22
210701	Гадаад албан томилолт	274,259,951.00	345,254,648.82
210702	Дотоод албан томилолт	54,938,670.00	72,448,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	96,990,703.02	90,152,337.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	886,569,342.16	912,335,300.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	834,468,980.00	874,137,124.45
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	48,500,000.00	34,800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,402,452.00	771,197.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	158,100.00	367,800.00
210807	Газрын төлбөр	158,400.00	1,218,210.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	881,410.16	1,040,969.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,325,658,343.62	4,376,215,700.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,490,711,656.22	2,133,098,405.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	834,946,687.40	2,243,117,294.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	507,438,002.00	453,136,056.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	507,438,002.00	453,136,056.30
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	138,240,728.00	106,372,624.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	143,071,500.00	27,192,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	226,125,774.00	319,571,332.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,800,649,537.37	1,401,158,010.98
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	2,400,000.00	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	2,400,000.00	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,033,737,120.00	4,608,530,955.18
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,033,737,120.00	4,608,530,955.18
2200	Дотоод эх үүсвэрээр	5,033,737,120.00	4,608,530,955.18
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,033,737,120.00	4,608,530,955.18
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(5,031,337,120.00)	(4,608,530,955.18)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	33,631,747.19	22,551,248.77
14	Бусад эх үүсвэр	39,365,312.46	22,551,248.77
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	39,365,312.46	22,551,248.77
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	5,733,565.27	-
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	5,733,565.27	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(197,055,835.44)	(3,184,821,695.43)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,183,722,480.07	25,986,666,644.63
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	25,986,666,644.63	22,801,844,949.20

4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,434,223,434.22	24,216,935,692.76	46,017,209,460.79	82,668,368,587.77
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,531,022,300.32)	(1,531,022,300.32)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,434,223,434.22	24,216,935,692.76	44,486,187,160.47	81,137,346,287.45
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	8,369,852,247.33	-	8,369,852,247.33
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,632,802,360.01	-	-	1,632,802,360.01
6	Тайлант үеийн үр дүн	-	-	3,870,518,823.97	3,870,518,823.97
7	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,067,025,794.23	32,586,787,940.09	48,356,705,984.44	95,010,519,718.76
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(3,854,889,804.52)	(3,854,889,804.52)
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,067,025,794.23	32,586,787,940.09	44,501,816,179.92	91,155,629,914.24
10	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(5,369,844.29)	-	(5,369,844.29)
11	Тайлант үеийн үр дүн	395,681,525.46	-	1,930,754,567.80	2,326,436,093.26
12	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,462,707,319.69	32,581,418,095.80	46,432,570,747.72	93,476,696,163.21

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	38,484,627,443.00	33,148,431,895.78	5,336,195,547.22	86.1
УРСГАЛ ЗАРДАЛ	38,484,627,443.00	33,148,431,895.78	5,336,195,547.22	86.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,678,231,453.48	31,421,414,033.48	5,256,817,420.00	85.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,718,683,446.17	17,668,345,484.50	50,337,961.67	99.7
Үндсэн цалин	17,718,683,446.17	17,668,345,484.50	50,337,961.67	99.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,531,240,492.31	2,206,524,682.84	324,715,809.47	87.2
Тэтгэврийн даатгал	1,721,243,534.77	1,514,947,276.32	206,296,258.45	88.0
Тэтгэмжийн даатгал	202,499,239.38	177,225,152.95	25,274,086.43	87.5
ҮОМШӨ-ний даатгал	161,999,391.51	140,370,835.26	21,628,556.25	86.6
Ажилгүйдлийн даатгал	40,499,847.88	33,244,373.95	7,255,473.93	82.1
Эрүүл мэндийн даатгал	404,998,478.77	340,737,044.36	64,261,434.41	84.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,477,032,617.00	1,585,556,361.39	891,476,255.61	64.0
Гэрэл, цахилгаан	529,145,892.00	527,035,331.55	2,110,560.45	99.6
Түлш, халаалт	1,495,686,350.00	841,041,073.17	654,645,276.83	56.2
Цэвэр, бохир ус	452,200,375.00	217,479,956.67	234,720,418.33	48.1
Хангамж, бараа материалын зардал	1,363,335,390.00	1,179,651,508.67	183,683,881.33	86.5
Бичиг хэрэг	143,071,900.00	139,971,023.00	3,100,877.00	97.8
Тээвэр, шатахуун	72,515,000.00	42,360,650.00	30,154,350.00	58.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	322,740,000.00	273,904,921.25	48,835,078.75	84.9
Ном, хэвлэл	240,214,400.00	179,132,551.18	61,081,848.82	74.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	57,245,000.00	44,383,147.00	12,861,853.00	77.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	527,549,090.00	499,899,216.24	27,649,873.76	94.8
Нормативт зардал	137,734,800.00	116,750,574.26	20,984,225.74	84.8
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,150,000.00	6,650,460.00	1,499,540.00	81.6
Хоол, хүнс	102,420,800.00	87,166,814.26	15,253,985.74	85.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл	27,164,000.00	22,933,300.00	4,230,700.00	84.4
Эд хогшил, урсгал засварын зардал	8,585,544,013.00	6,106,966,399.80	2,478,577,613.20	71.1
Багаж, техник, хэрэгсэл	2,564,478,190.00	2,249,247,199.00	315,230,991.00	87.7
Тавилга	596,819,700.00	330,829,867.00	265,989,833.00	55.4
Урсгал засвар	5,424,246,123.00	3,526,889,333.80	1,897,356,789.20	65.0
Томилолт, зочны зардал	712,710,435.00	507,855,586.22	204,854,848.78	71.3
Гадаад албан томилолт	446,785,060.00	345,254,648.82	101,530,411.18	77.3
Дотоод албан томилолт	99,190,375.00	72,448,600.00	26,741,775.00	73.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	166,735,000.00	90,152,337.40	76,582,662.60	54.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,327,029,534.00	934,227,315.95	392,802,218.05	70.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,234,034,734.00	897,119,139.45	336,915,594.55	72.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	83,000,000.00	34,800,000.00	48,200,000.00	41.9

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тээврийн хэрэгслийн татвар	3,716,800.00	771,197.00	2,945,603.00	20.7
Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,678,000.00	367,800.00	1,310,200.00	21.9
Газрын төлбөр	2,300,000.00	128,210.00	2,171,790.00	5.6
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,300,000.00	1,040,969.50	1,259,030.50	45.3
Бараа үйлчилгээний бусад зардал	1,824,920,726.00	1,115,536,119.85	709,384,606.15	61.1
Бараа үйлчилгээний бусад зардал	247,275,208.00	133,098,405.95	114,176,802.05	53.8
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,577,645,518.00	982,437,713.90	595,207,804.10	62.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,806,395,989.52	1,727,017,862.30	79,378,127.22	95.6
Бусад урсгал шилжүүлэг	1,806,395,989.52	1,727,017,862.30	79,378,127.22	95.6
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	143,308,200.00	143,308,200.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,663,087,789.52	1,583,709,662.30	79,378,127.22	95.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,924,087,172.00	33,146,377,839.07	(1,777,709,332.93)	94.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,617,032,617.00	143,308,200.00	(2,473,724,417.00)	5.5
Улсын төсвөөс санхүүжих	2,477,032,617.00		(2,477,032,617.00)	0.0
Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	140,000,000.00	143,308,200.00	3,308,200.00	102.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	32,307,054,555.00	33,003,069,639.07	696,015,084.07	102.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,231,023,132.00	28,218,817,579.00	(12,205,553.00)	100.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,076,031,423.00	4,784,252,060.07	708,220,637.07	117.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		25,986,666,644.43		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		22,801,844,949.20		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн	Аудитын код:
2020.03.10			САГ-2020/78/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол Улсын Боловсролын Их сургууль		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бараа материалын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй	145.7	Зөвлөмж өгсөн	МУБИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч МУБИС-ийн ерөнхий нягтлан бодогч	Д.Мандах
2	НББ-ийн програм хангамжид шинэчлэл хийгээгүй	-	Зөвлөмж өгсөн		Д.Саранчимэг
3	Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй	-	Зөвлөмж өгсөн		

